



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 21 өдөр

Дугаар А/104

Чингис хот

Зохион байгуулалтын
арга хэмжээ авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.6, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 32.1.8 дахь заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62, 64 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 07 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх, аймаг, сумдаас гарах, орох иргэд болон автомашины хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 23-ны өдрийн 08:00 цагаас 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 08:00 цаг хүртэлх хугацаанд түр хязгаарласугай.

2. Өмнөдэлгэр сумын нутаг Бурхан халдун хайрхан, Мөрөн сумын 3 дугаар багийн нутаг Өндөрхаан хайрхан Шинийн нэгний нар харах болон сумдын тахилгатай уул, овооны чиглэлийн хөдөлгөөнийг 2020 оны 03 дугаар сарын 31-ний өдөр хүртэл хязгаарлаж ажиллахыг сумын Засаг дарга нарт, хөдөлгөөний хязгаарлалтад хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /хурандаа Б.Батсайхан/-т үүрэг болгосугай.

3. Иргэдийн эрүүл мэнд, бие бялдарыг хөгжүүлэх, дархлааг дэмжих зорилгоор спорт заал, /Ерөнхий боловсролын сургууль, Политехникийн коллеж, Мэргэжил сургалт үйлдвэрийн төвийн заал бусад/ бялдаржуулах төвийн үйл ажиллагааг насанд хүрэгчдэд 15 хүнээс ихгүйгээр оролцуулан дасгал сургууль хийлгэхийг Биеийн тамир, спортын газрын дарга Г.Нэргүйбаатар, хүнсний зах, худалдааны төв, дэлгүүр, аж ахуйн нэгж байгууллагуудад ариутгал халдваргүйтгэл хийж, мэргэжлийн зөвлөгөө өгч ажиллахыг Зооноз өвчин судлалын төвийн дарга Г.Наранхүү, эрүүл ахуй, ариун цэврийн хэвийн үйл ажиллагааг хангуулан хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга Б.Сүнгээ нарт даалгасугай.

4. Орон нутгийн түвшинд сар шинийн золголт хийж буйд хяналт тавьж, сэрэмжлүүлэг мэдээлэл уриалгыг ард иргэдэд хүргэж ажиллахыг хэвлэл мэдээллийн байгууллагын захирлуудад, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

731910787

2.

5. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас /ар гэрийн гачигдал, эмнэлгийн яаралтай тусламж үйлчилгээ, албан томилолт, ажлын зайлшгүй гэх мэт/ улс, хот хооронд зорчих төрийн алба хаагч болон иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр зорчих хуудас олгохыг аймаг, сумдын шуурхай штабын дарга нарт даалгасугай.

6. Хязгаарлалтын дэглэм тогтоосонтой холбогдон гарах зардлыг гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

7. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Г.Хэрлэнчулуун/, Шуурхай штабын дарга /дэд хурандаа Н.Чанцал/ нарт тус тус даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА